

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 12 дугаар
сарь н 14-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн
Н.Наранбаатар**

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулах хууль, эрх зүйн орчин тодорхойгүй байгаагаас экспортын 90 орчим хувь, төсвийн орлогын 30 орчим хувийг бүрдүүлдэг хүнд үйлдвэрийн гаралтай бүтээгдэхүүнд технологийн багтаамжгүй, боловсруулаагүй түүхий эд эзэлж байгаа нь дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах, нэмүү өртөг шингэсэн импортыг орлох, экспортын чиг баримжаатай хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай болсон.

Иймд хууль санаачлагч Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэгдсэн түүхий эд, эрдэс баялгийн нөөцөд тулгуурлан хүнд үйлдвэрийг төрийн нэгдсэн бодлогоор дэмжих, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, хүнд үйлдвэрийн эрчимтэй хөгжлийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг тусгасан Хүнд үйлдвэрийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулсан байна.

Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл дэх зохицуулалтууд нь иргэн, төрийн байгууллагад нэмэлт зардал үүсгэхгүй бөгөөд төрөөс гүйцэтгэх үүрэгтэй холбоотойгоор нэг аж ахуйн нэгжээс дунджаар 302,5 мянган төгрөгийн зардал гарахаар байгаагийн дийлэнх нь улсын тэмдэгтийн хураамж хэлбэрээр улсын төсөвт төвлөрнө.

Хүнд үйлдвэрийн тухай хууль хэрэгжсэнээр хүнд үйлдвэр дагасан үйлдвэрүүд олноор бий болж, 5000 гаруй ажлын байрыг шинээр бий болгон, улсын болон орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэмэгдэх юм.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар хүчин чадал, тусгай шаардлагын ямар ангилалд багтах үйлдвэрүүдийг хүнд үйлдвэр гэж үзэх, хуулийн төсөл батлагдсанаар гарах үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хуулийн төсөлд хүнд үйлдвэрүүдэд төрөөс дэмжлэг үзүүлсэн эрх зүйн ямар орчинг бүрдүүлж байгаа болон бүтээгдэхүүний өртөг, зардлыг бууруулахтай холбоотой асуудлыг хэрхэн

шийдвэрлэсэн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд уул уурхайн бүтээгдэхүүнийг баяжуулах болон боловсруулах шатны үйлдвэрүүд хүнд үйлдвэрийн ангилалд орох эсэх, хуулийн төсөл батлагдсанаар одоо үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдэд хэрхэн нөлөөлөх болон улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ нэмэгдэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут хуулийн төсөлд хүнд үйлдвэрт ажиллаж байгаа ажилчдын нийгмийн баталгааны асуудлыг тусгасан эсэх, мөн үйлдвэрээс гарах химийн болон аюултай хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр хэрхэн устгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин хүнд үйлдвэрүүдийг бүсчлэн хөгжүүлэхтэй холбоотой баримталж байгаа бодлогын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Н.Наранбаатар, Г.Ганболд нар хуулийн төсөлд тусгагдсан хүнд үйлдвэрийн тодорхойлолтыг оновчтой болгох, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Т.Энхтүвшин нар бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээж байгаа үйлдвэрүүдийг хүнд үйлдвэрийн ангилалд оруулах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Н.Наранбаатар, Т.Энхтүвшин, Г.Дамдинням нар хуулийн төсөлд тусгагдаагүй зарим зохицуулалтуудыг нэмж тусгуулахаар хууль санаачлагчид нь буцаах, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Л.Мөнхбаатар, Ж.Бат-Эрдэнэ нар хуулийн төслийг дэмжиж, ажлын хэсгийн түвшинд дахин хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 69,2 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүнд үйлдвэрийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Үйлдвэрлэл, технологийн ларкийн эрх зүйн байдлыг тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Б.ЧОЙЖИЛСҮРЭН